



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991
Affiliated to FINA, 1996
Affiliated to AASF, 2000

Mongolia, Ulaanbaatar, Khan-uul district,
National Olympic committee building, Room 115
Tel: (976)-88131777, (976)-99131777
Email: secretariat@mongoliaaquatics.mn
www.mongoliaaquatics.mn

2026 оны 03-р сарын 13 -ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

МУССХ-ны “Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамруулах үеийн эрсдлийн удирдлага хариуцлагын журам”-ыг батлах тухай

“Монголын усан спорт сонирхогчдын холбоо” төрийн бус байгууллага (“Холбоо” гэх)-ын Удирдах зөвлөлийн хурал нь Холбооны дүрмийн 11.7.10-т Удирдах зөвлөл нь “Байгууллагын дотоод журам батлах” асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ гэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Холбооны “Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамруулах үеийн эрсдлийн удирдлага хариуцлагын журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Журмыг Холбооны бүх гишүүдэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллахыг ЕНБД М.Энхбаатар болон Дасгалжуулагчдын зөвлөл, Ёс зүйн зөвлөлд үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Батайхан

П.БАТСАЙХАН

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ТАМИРЧНЫГ ДОТООДЫН БОЛОН ГАДААД УЛСАД ТЭМЦЭЭН,
БЭЛТГЭЛ СУРГУУЛИЛТАД ХАМРУУЛАХ ҮЕИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА,
ХАРИУЦЛАГЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Журмын зорилго.

Энэхүү журам нь Монголын усан спорт сонирхогчдын холбооны (цаашид “Холбоо” гэх) гишүүн клубууд насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улс оронд бэлтгэл сургуулилт, спортын цугларалт, тэмцээнд оролцуулах үед клуб, дасгалжуулагч болон эцэг эхийн хариуцлагын заагийг тогтоох, эрсдэлийн удирдлага, аюулгүй байдлын зохицуулалтыг бий болгох зорилготой.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэн ажиллах талууд.

- Холбоо
- Холбооны гишүүн клуб, байгууллага
- Дасгалжуулагч, багийн ахлагч
- Насанд хүрээгүй тамирчин
- Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч

ХОЁР. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ТАМИРЧНЫГ ГАДААД УЛС БОЛОН
ДОТООДОД ЗОРЧУУЛАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Гадаад улсад зорчиж байгаа бол клуб нь холбоонд хүсэлт гаргаж, Эрүүгийн цагдаагийн албанаас тамирчдыг хариуцаж явах багш, дасгалжуулагчийг гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүй тухай тодорхойлолт хүссэн албан тоотыг авсан байх.

2.2. Гадаад улсад зорчиж байгаа бол хариуцаж явах багш, дасгалжуулагчийг гэмт хэрэг зөрчилд холбогдож байгаагүй тухай тодорхойлолтыг Эрүүгийг цагдаагийн газраас авсан байх.

2.3. Гадаад улсад зорчиж байгаа бол Нотариатын байгууллагаар итгэмжлэл хийлгэсэн байх.

2.4. Дасгалжуулагч нь хүүхэд хамгааллын асуудлаар сайн мэдлэгтэй байх, ёс зүйн сургалтад хамрагдсан байх

2.5. Бүх тамирчид, дасгалжуулагчид аяллын болон эрүүл мэндийн даатгалтай байх

2.6. Эцэг эх, асран хамгаалагчдаар “ХАБЭА-н зааварчилгаа, эцэг эхийн зөвшөөрлийн хуудас”-ыг бөглүүлж, гарын үсэг зурж баталгаажуулсан байх

2.7. Дасгалжуулагч, эцэг эх, асран хамгаалагчид болон тамирчдад “Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамруулах үеийн аюулгүй байдлын зааварчилгаа”-г танилцуулж гарын үсэг зурүүлж баталгаажуулсан байх.

ГУРАВ. ТАЛУУДЫН ҮҮРЭГ

3.1. Холбооны үүрэг

- Журмын хэрэгжилтэд хяналт тавих
- Клубын багш, дасгалжуулагч нарт эрсдлийн удирдлага, хүүхэд хамгааллын зааварчилгаа, зөвлөмж өгөх
- Гадаад улсад зорчих бол бэлтгэл болон тэмцээнд оролцох багийн насанд хүрээгүй тамирчдын тоо, нэрсийг баталгаажуулах. Эрүүгийн цагдаагийн албанд тодорхойлолт хүссэн албан тоотыг илгээснээр тамирчдын нэрсийг баталгаажсан гэж үзнэ.

3.2. Клубын үүрэг

- Тамирчин, дасгалжуулагч багш нарынхаа дотоодын болон гадаад улсад зорчиход шаардлагтай эрхзүйн баримт бичгийг бүрдүүлэх. (Нотариатаар батлуулсан итгэмжлэх, Цагдаагийн тодорхойлолт, Тамирчдын хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам, ХАБЭА-н зааварчилгаа, Эцэг эхийн зөвшөөрлийн хуудас, Аюулгүй байдлын зааварчилгаа)
- Аяллын болон эрүүл мэндийн даатгалыг бүрэн хийсэн байх
- Багш, дасгалжуулагч нарыг ёс зүйн болон хүүхэд хамгааллын шаардлагад нийцсэн эсэхийг баталгаажуулах
- Дасгалжуулагчид, тамирчдын баримт бичиг, эрүүл мэндийн мэдээллийг бүрдүүлэх

3.3. Дасгалжуулагч (багийн ахлагч)-ийн үүрэг

- Тамирчдыг хариуцсан хугацаанд аюулгүй байдлыг хангах, дэг журам, өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэх
- Хүүхэд хамгааллын заавар мөрдөх
- Зааварчилгаа өгөх, дэг журмыг мөрдүүлэх
- Эрсдэл үүссэн үед шүүрхай арга хэмжээ авах
- Үүсэж болзошгүй болон үүссэн эрсдлийн талаархи мэдээллийг Холбоо, Клуб болон Эцэг эх, асран хамгаалагчдад шуурхай өгөх.

3.4. Тамирчны үүрэг

- Дасгалжуулагчийн өгсөн заавар, цагийн хуваарийг мөрдөх
- Зөвшөөрөлгүй газар явахгүй байх, бие даан шийдвэр гаргахгүй байх
- Хориглосон бүтээгдэхүүн хэрэглэхээс татгалзах
- Эм бэлдмэлийг зөвшөөрөлгүй хэрэглэхгүй байх
- Хоол хүнсний аюулгүй байдлын талаархи зааврыг дагаж мөрдөх
- Гар утас, цахим орчны зохисгүй хэрэглээнээс татгалзах

3.5. Эцэг эхийн үүрэг

- Тамирчны эрүүл мэндийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх
- Аяллын зөвшөөрөл, хариуцлагын баталгааг гаргаж өгөх
- Хүүхдэдээ сахилга батыг сахиж, дэг журам мөрдөх талаар урьдчилан зааварчилсан байх

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

Дасгалжуулагчийн ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ нөхцөл

4.1. Анхаарал, хяналт сүлрүүлсэн буруутай үйлдэл

- Тамирчдыг хариуцаж явах хугацаанд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, тамирчдыг өөрийн хяналтаас гадуур байлгасан
- Зохион байгуулалтын тодорхой заавар зөрчсөн
- Орон байр, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг шалгаагүй
- Өөрийн мэдлэг, үр чадварын дутагдал, хайхрамжгүй үйлдлээс болж эрсдэл үүсгэсэн

4.2. Хүүхдийн эрхийг зөрчсөн, ёс зүйн зөрчил

- Хараал, доромжлол, хүч хэрэглэсэн
- Сэтгэл санааны дарамт, ялгаварлан гадуурхалт
- Бэлгийн дарамт, зохисгүй харилцаа
- Хүүхэд хамгааллын бодлого зөрчсөн

4.3. Эрүүл мэнд, ослын үед арга хэмжээ аваагүй

- Тамирчин өвдөх, гэмтэх үед анхны тусламж үзүүлээгүй, зохих эмнэлгийн тусламж хүсээгүй
- Холбогдох байгууллагад мэдээлээгүй
- Эрсдэлийн нөхцөл байдлыг үл тоомсорлосон

Дасгалжуулагч ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ нөхцөл:

4.4. Дасгалжуулагчийн хяналтаас бүрэн гадуурх нөхцөл. Үүнд:

- Гэнэтийн эмгэг (төрөлхийн өвчин, архаг эмгэг сэдрэх, харшлын хүнд хэлбэр)
- Байгалийн гамшиг, онцгой байдал, гуравдагч этгээдийн гэмт халдлага болон аяллын явцад олон нийтийн газар гарсан тохиолдол (нисэх буудал, буудал гэх мэт)
- Дасгалжуулагчийн шууд хяналтад байх боломжгүй бүс (буудлын өрөө, бассейны гаднах олон нийтийн бүс, орох хориотой бүс)

4.5. Тамирчны буруутай үйлдэл

- Дасгалжуулагчийн заавар, дэглэм, цагийн хуваарийг зөрчсөн
- Зөвшөөрөлгүй газар явах, бие даан шийдвэр гаргаснаас үүссэн эрсдэл
- Хориглосон бүтээгдэхүүн хэрэглэх (сэргээш, согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэл)
- Хоол хүнс, эрүүл мэндийн зааврыг зөрчсөн
- Гар утас, цахим орчны зохисгүй хэрэглээнээс үүдсэн эрсдэл

4.6. Эцэг эхийн мэдээллийн үнэн зөв бүс байдал

- Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийн эрүүл мэндийн талаарх бодит мэдээллийг нуусан
- Хүүхдэдээ аюулгүй байдлын анхан шатны зааврыг өгөөгүй
- Хүндэрсэн өвчнийг мэдэгдээгүй
- Сэтгэлзүйн онцлог, зан авирын эмгэгийг мэдээлээгүй

ТАВ. ЭРСДЭЛ ҮҮССЭН НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Шуурхай арга хэмжээ

- Аюулгүй байдлыг хангах
- Эмнэлгийн тусламж авах

- Орон нутгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх (цагдаа, галын дуудлага, Монгол улсын элчин сайдын яам, консулсын газар, арга хэмжээг зохион байгуулж буй байгууллага)
- Холбоо, клуб, эцэг эх, асран хамгаалагчид яаралтай мэдээлэх

5.2. Баримтжуулалт

- Үйл явдлын тайлан
- Эмнэлгийн дүгнэлт, санхүүгийн харилцааны баримтууд, бодит нөхцөл байдлын зураг
- Гэрчийн мэдүүлэг
- Орчны нөхцөл, байр болон тээвэрлэлтийн мэдээлэл

ЗУРГАА. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА, ХАРИУЦЛАГЫН ЖУРМЫГ ЗӨРЧСӨН

ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

6.1 Энэхүү журмын болон гэрээний шаардлага, дэг журмыг зөрчсөн этгээдэд хариуцлага тооцохдоо дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- Зөрчлийн шинж, хор үршиг, давтамж
- Хүүхэд хамгааллын эрсдэл үүссэн эсэх
- Дасгалжуулагчийн шүүд хяналттай болон хяналтаас гадуурх нөхцөл
- Холбогдох тайлбар, нотлох баримт

6.2. Тамирчинд хүлээлгэх хариуцлага

Тамирчны буруутай үйлдлээс үүдэн журмын шаардлага зөрчигдвөл дараах шат дараалсан хариуцлагыг оногдуулна.

6.2.1. Сахилгын анхан шатны арга хэмжээ

- Анхааруулга өгөх (аман, эсвэл бичгээр)
- Өдөр тутмын хяналтыг чангатгах
- Хувийн хөдөлгөөнд түр хязгаарлалт тогтоох (олон нийтийн газарт зорчихыг хориглох гэх мэт)

6.2.2. Дунд шатны арга хэмжээ (Зөрчил давтагдсан, эсвэл бүсдын болон өөрийн аюулгүй байдалд эрсдэл учруулсан бол:

- Тэмцээн/бэлтгэлийн тодорхой өдрийн оролцоог хасах
- Багийн ахлагчийн хараа хяналтыг нэмэгдүүлэх
- Дотоод дүрэм зөрчсөн талаарх бичгэн мэдэгдэл эцэг эхэд хүргүүлэх

6.2.3. Хүнд зөрчил гаргасан тохиолдолд (зугтах, зөвшөөрөлгүй газар явах, архи/тамхи хэрэглэсэн, баг хамт олонд аюул үүсгэсэн, зодолдох, ёс зүйн ноцтой зөрчил гэх мэт)

- Бэлтгэл, тэмцээнийг дуусгалгүй буцаах шийдвэр (зардлыг эцэг эх хариуцна)
- Холбооны дараагийн 3-12 сарын тэмцээн/бэлтгэлд оролцох эрхийг хасах
- Гэмт хэргийн чанартай үйлдлийг холбогдох байгууллагад мэдэгдэх

6.3. Дасгалжуулагч, багийн ахлагчид хүлээлгэх хариуцлага

Дасгалжуулагч нь насанд хүрээгүй тамирчны аюулгүй байдлыг шүүд хариуцагч тул зөрчлийн түвшин, хор үршгийг харгалзан дараах хариуцлагыг ногдуулна.

6.3.1. Анхан шатны хариуцлага

- Аман анхааруулга өгөх

6.3.2. Дунд шатны хариуцлага (Дасгалжуулагчийн бүрүүтэй үйлдлээс эрсдэл үүссэн, хяналт сулруулсан, дэг журам тогтоох үүргээ биелүүлээгүй тохиолдол)

- Гадаад томилолтод оролцох эрхийг 3–12 сар хүртэл хасах
- Хүүхэд хамгааллын сургалтад дахин хамруулах
- Холбооны дэргэдэх Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх

6.3.3. Хүнд зөрчил гаргасан тохиолдолд (Архидан согтуурах, хүүхдийн эрх зөрчих, доромжлох, айлган сүрдүүлэх, бэлгийн дарамт, биед хүрэх г.м, Хайхрамжгүй байдлаас нь болж тамирчны амь нас, эрүүл мэндэд ноцтой хор уршиг учруулсан, Эрсдлийн мэдээллийг нуун дарагдуулсан, Гэмт хэрэгт шинж чанартай үйлдэл)

- Гадаад болон дотоод бүх тэмцээн, бэлтгэлийн томилолтод оролцох эрхийг 1–3 жилээр хасах
- Ёс зүйн хорооны шийдвэрээр дасгалжуулагчийн эрхийг түдгэлзүүлэх эсвэл хасах
- Гэмт хэргийн чанартай үйлдлийг хуулийн байгууллагад шилжүүлэх

6.4. Клубын хүлээх хариуцлага

Клуб өөрийн хяналт, зохион байгуулалтын үүргээ биелүүлээгүй бол:

6.4.1. Анхан шатны хариуцлага

- Албан сануулга
- Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжилтийн хяналтыг нэмэгдүүлэх үүрэг өгөх

6.4.2. Дунд шатны хариуцлага

- Холбооны тэмцээн болон бэлтгэлийн үйл ажиллагаанд клубын оролцоог түр хязгаарлах
- Зөрчилтэй багш/туслах ажилтныг солих, сургалтанд дахин хамруулах үүрэг өгөх

6.4.3. Хүнд зөрчил гарсан бол

- Холбооны үйл ажиллагаанд оролцох эрхийг 3–12 сар хязгаарлах
- Хүүхэд хамгааллын бодлогыг удаа дараа ноцтой зөрчсөн бол гишүүнчлэлийг түдгэлзүүлэх

6.5. Эцэг эх / Асран хамгаалагчийн хариуцлага

Эцэг эхийн өгсөн мэдээллийн худал, нуун дарагдуулсан байдлаас эрсдэл гарсан бол:

- Хүүхэд дахин гадаадад улсад бэлтгэл болон тэмцээнд оролцохыг хязгаарлах
- Холбоонд учирсан гэм хор, нэмэлт зардал гарсан бол нөхөн төлүүлэх
- Хүнд тохиолдолд хүүхдийн Холбооны бүхий л үйл ажиллагаанд оролцох оролцоог 3–12 сар хязгаарлах

ДОЛОО. НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ, ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ

7.1. Шалгалтын үйл явц

- Хөнгөн зөрчлийг клуб бие даан шалгаж шийдвэрлэнэ.

- Дунд түвшний зөрчлийг Холбооны гүйцэтгэх удирдлага шалгаж шалгалтын үр дүнг Ёс зүйн зөвлөлд шилжүүлж шийдвэрлүүлнэ.
- Хүнд түвшний зөрчлийг Холбооны гүйцэтгэх удирдлага болон Ёс зүйн зөвлөлийн төлөөлөл оролцсон баг шалгаж тайланг Удирдах зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- Үйл явдлын талаар албан мэдээлэл ирсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор урьдчилсан шалгалт эхлүүлэх
- Дасгалжуулагч, тамирчин, гэрч, клубын тодорхойлолтыг авах
- Хяналтын камер, бичлэг, чат, эмнэлгийн дүгнэлт, санхүүгийн баримт зэргийг цуглуулах

7.2. Шийдвэр гаргах

- Хөнгөн зөрчил — багийн ахлагч/клуб шийдвэрлэнэ.
- Дунд зөрчил — Холбооны Ёс зүйн зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.
- Хүнд зөрчлийг Холбооны Удирдах зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.
- Шийдвэрийг 3 ажлын өдрийн дотор эцэг эх, клуб, дасгалжуулагчид бичгээр мэдэгдэнэ

НАЙМ. ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ БА ЭРХ СЭРГЭЭХ

8.1. Дараах тохиолдолд буруутай этгээд нөхөн төлбөр төлөх үүрэгтэй:

- Тамирчин санаатай болон санамсаргүй буруутай үйлдлээр байр, тоног төхөөрөмж эвдсэн
- Дасгалжуулагчийн хайхрамжгүй байдлаас холбоо болон клубт санхүүгийн хохирол учирсан
- Гадаад бэлтгэлээс хугацаанаас өмнө буцахад гарсан зардлыг буруутай этгээд (эсвэл эцэг эх) төлөх

8.1. Эрх сэргээх боломж

Хариуцлага хүлээлгэсэн этгээд дараах нөхцөлд эрхээ сэргээлгэх боломжтой:

- Заавал суух сургалтуудад хамрагдсан. (Ёс зүй, хүүхэд хамгаалал, эрсдэлийн удирдлага)
- Нөхөн төлбөрийг бүрэн барагдуулсан.
- Удирдах зөвлөл эсвэл Ёс зүйн зөвлөлөөс “сэргээх шийдвэр” гаргасан.
- Шийтгэлийн хугацаа дууссан.

ДОЛОО. ХАВСРАЛТ БАРИМТ БИЧИГ

7.1. Хавсралт 1. “Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамруулах үеийн эрсдлийн удирдлага, хариуцлагын журам”-ын ХАБЭА-н зааварчилгаа, эцэг эхийн зөвшөөрлийн хуудас

7.2. Хавсралт 2. Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамруулах үеийн аюулгүй байдлын зааварчилгаа (дасгалжуулагч)

7.3. Хавсралт 3. Тэмцээн бэлтгэлд оролцох тамирчны эцэг эх, асран хамгаалагчдад өгөх аюулгүй байдлын зааварчилгаа (Эцэг эх, асран хамгаалагч)

7.4. Хавсралт 4. Тэмцээн, бэлтгэлд оролцох тамирчинд өгөх аюулгүй байдлын зааварчилгаа (Тамирчин)

НАЙМ. МӨРДӨХ ХУГАЦАА

8.1. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд журам батлагдахаас өмнөх аливаа асуудалд буцаан хэрэглэхгүй.

**“Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад
хамруулах үеийн эрсдлийн удирдлага, хариуцлагын журам”-ын ХАБЭА-н зааварчилгаа, эцэг
эхийн зөвшөөрлийн хуудас**

2026/___/___

Урьдчилсан зааварчилгаа

1. Дотоодын болон гадаад улсад тэмцээн, бэлтгэл сургуулилтад багийн ахлагч болон дасгалжуулагчдын хяналтан дор зохион байгуулалттайгаар оролцоно.
2. Дотоод (гадаад улс) тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамрагдах газар (улс) уруу клуб, эцэг эхчүүдийн зохион байгуулсан тээврийн хэрэгслээр зорчино.
3. Өөрийн эд зүйл, хувцсанд эзэн болно.
4. Эмх цэгцтэй, бусдыгаа хүндэлж, бусдын болон өөрийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулахгүй байх.
5. Дасгалжуулагчийн болон зохион байгуулагчийн зааварчилгаа, зөвлөгөөг нэг бүрчлэн дагана.
6. Зочилж буй газар очихдоо хариуцаж буй дасгалжуулагчийн зөвлөгөө, зааварчилгааны дагуу заасан газар зогсох, оролцох, тухайн газрын дэг журмыг мөрдөнө.
7. Багийн ахлагч/дасгалжуулагчийн ярьж буй яриаг анхааралтай сонсох,
8. Зохион байгуулагчийн зөвшөөрөлгүйгээр өөр тийшээ явахгүй байх, баг хамт олонтойгоо хамт байх,
9. Зөвшөөрөгдөөгүй хоол хүнс хэрэглэхгүй байх,
10. Хамт олноосоо хоцрохгүй, өөр чиглэл дүр мэдэн ганцаар болон хэсэг бүлгээрээ явахгүй байх,
11. Очсон газрын болон тухайн байгууллагын дүрэм журмыг мөрдөх,
12. Эрүүл аюулгүй байдлаа хангах, тамирчид хувцсаа тохируулан өмсөх.
13. Бусдад ямар нэгэн байдлаар аюул учруулж болзошгүй зүйл авч явахгүй байх
14. Явах болон буцаж ирэх үед эцэг эх, асран хамгаалагчид гарган өгч/хүлээн авна.

Зөвшөөрлийн хуудас:

2026 оны ___ сарын ___-ний өдөр болох _____ газар/улс-д (зурах) зохион байгуулагдах “_____” тэмцээн/бэлтгэл-д (зурах) өөрийн хүүхдийг явуулахыг зөвшөөрч байна.

Цугларах цэг/цаг: _____

Тарах цэг/цаг : _____

..... клубын тамирчин-ийн/-ын/

Эцэг, эхийн нэр: /овог, нэр/

Эцэг, эхийн гарын үсэг: гар утас:.....



**Насанд хүрээгүй тамирчныг дотоодын болон гадаад улсад
тэмцээн, бэлтгэл сургуулилтад хамруулах үеийн аюулгүй байдлын
зааварчилгаа (дасгалжуулагч)**

БАГШИЙН ОВОГ, НЭР	
ХАРИУЦАН АВЧ ЯВАХ ТАМИРЧДЫН ТОО	
ТЭМЦЭЭНИЙ НЭР / БЭЛТГЭЛИЙН НЭР	
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ХАЯГ	
ХУГАЦАА	
ГАЗАР/УЛСЫН НЭР	☐ УЛС ☐ ОЛОН УЛС

Бэлтгэл, тэмцээний өмнө хэрэгжүүлэх аюулгүй байдлын зааварчилгаа:

- Бэлтгэл, тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах, тухайн мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчдад мэдээллэх
- Бэлтгэл, тэмцээний талаарх шаардлагатай мэдээллээр холбоо, эцэг эх, асран хамгаалагчдыг хангах, үүнд:
 - Үйл ажиллагаа болох газар, зохион байгуулалт, хугацаа
 - Аялалын тээврийн хэрэгсэл, маршрут, цаг, тарах цуглах цаг, газар
 - Үйл ажиллагааны бэлтгэл, шаардлагатай зүйлсийн жагсаалт
 - Байрлах байр, хоолны мэдээлэл
 - Үйл ажиллагааны зардал, төлбөр, бүртгэл, тийз
 - Эцэг эхчүүдийн итгэмжлэл, зөвшөөрлийн хуудас

Тэмцээн бэлтгэлийн үеэр хэрэгжүүлэх аюулгүй байдлын зааварчилгаа:

- Тэмцээн, бэлтгэл зохион байгуулагдаж буй газрын талаар тамирчид болон дагалдан яваа хүмүүст дараах мэдээллийг заавал өгнө. Үүнд:
 - Тухайн газрын ерөнхий зохион байгуулалт, онцгой байдлын үеийн аврах гарцын зураг болон орох, гарах хаалга, бие засах газар, цугларах цэгийн байршил, тэмцээний зохион байгуулагчид, мэдээллийн ажилтан байрлаж буй хэсгийг хэлж өгөх
 - Тэмцээн, бэлтгэлийн үеэр өөрөө хаана байх, ямар тохиолдолд өөрт нь хандаж болох тухай дэлгэрэнгүй хэлж өгөх
 - Тэмцээн эхлэх болон дуусах цаг, уулзах цэгийг харилцан тохирох
 - Гэнэтийн осол, төөрөх зэрэг эрсдэл гарах үед авах арга хэмжээний дарааллыг танилцуулах. Үүнд:

Төөрсөн үед - Тайван байх	→	Алхам 1. Багийнхнаасаа төөрсөн эхний байршилдаа буцаж очиж хүлээх.	Алхам 2. Боломжтой хэрэгслээр холбоо барих	Алхам 3. Зохион байгуулагчид /үнэмлэхтэй, дүрэмт хувцастай/-аас тусламж хүсэх.	Алхам 4. Хамгийн ойр байрлах, цагдаагийн газар хандах.
Гэнэтийн ослын үед – Тайван байх		Хүүхдийн нөхцөл байдал, биеийг шалгах, үнэлэх Анхан шатны тусламж үзүүлэх	Шаардлагатай тохиолдолд эмнэлэгийн тусламж дуудах, хүргэх	Зохион байгуулагч байгууллага, ажилтанаас тусламж хүсэх	Холбоо, эцэг эх, асран хамгаалагчдад мэдэгдэх

- Тэмцээн, бэлтгэлд оролцогч тамирчдыг тухайн оролцох үйл ажиллагаанд зохион байгуулалтаар ханган сахилга бат, дэг журмыг сахиулан оролцуулах
- Уралдаан, тэмцээний үр дүнг эерэгээр тайлбарлах, ялах, ялагдах чанарыг тамирчдад хэлж ойлгуулах
- Үйл ажиллагааны тайлан дүн мэдээг цаг хугацаанд нь гаргах, Холбоо, эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэх
- Тамирчидтай хүндэтгэлтэй харьцах ба дасгалжуулагчийн хүний ёс зүйг дээдлэн ажиллах
- Үндсэн үйл ажиллагаа, чөлөөт цаг зэрэг аялалын туршид тамирчдыг бүрэн хариуцаж ажиллах
- Тамирчин нэг бүрд тухайн газар, орон үйл ажиллагаатай хамааралтай аюулгүй байдлын зөвлөгөө өгөх, болзошгүй эрсдлийг таниулан тайлбарлаж сэргийлэх

Нэмэлт тэмдэглэл:

Танилцсан:

Дасгалжуулагчийн нэр:

Гарын үсэг _____ Огноо _____



**Тэмцээн бэлтгэлд оролцох тамирчны эцэг эх, асран хамгаалагчдад өгөх аюулгүй
байдлын зааварчилгаа (Эцэг эх, асран хамгаалагч)**

ТАМИРЧНЫ ОВОГ, НЭР	
КЛУБЫН НЭР	
ОРОЛЦОХ ТЭМЦЭЭНИЙ НЭР, ТӨРӨЛ	
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР	
ХУГАЦАА	
ГАЗАР/УЛСЫН НЭР	☐ УЛС ☐ ОЛОН УЛС

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ

- Тэмцээн, бэлтгэлийн бэлтгэл ажил, сургалтанд бүрэн хамруулах, хариуцлагатай хандах
- Хэрвээ бүртгэл захиалга хийгдсэний дараа оролцуулахаас татгалзах тохиолдолд холбогдох зардлыг бүрэн хариуцах
- Оролцох үйл ажиллагаанд тохирсон хувцас, хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг бүрэн бэлтгэж явуулах
- Тухайн газар орон, цаг агаарын нөхцөлд тохирсон биед эвтэйхэн, дулаан хувцас, хувийн бэлтгэлийг сайтар хангах
- Хүүхэд ачаагаа бие даан тээвэрлэхэд хялбар байхаар хэмжээг анхаарах
- Тэмцээн, бэлтгэлд хамт явахаар бол тухайн хугацааны туршид хүүхдийнхээ аюулгүй байдлыг эцэг эх, асран хамгаалагч хариуцах
- Тамирчны эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс явах боломжгүй бол албан итгэмжлэл үйлдэх
- Дасгалжуулагч нар тамирчдыг тэмцээн, бэлтгэлд оролцуулах үүрэгтэй бөгөөд бусад хугацаанд гарч болзошгүй гуравдагч этгээдээс үүдэлтэй эрсдлийг эцэг эх, асран хамгаалагчид хариуцах
- Тамирчныг гэнэтийн ослын даатгал болон тээврийн даатгалд заавал хамруулах
- Аялалын туршид хүүхдийн сэтгэл зүйг дэмжиж, холбоо харилцаатай байх
- Хариуцагч дасгалжуулагчид зайлшгүй мэдэгдэх шаардлагатай дараах мэдээллийг бөглөж өгнө үү:

Харшилдаг зүйлс /хоол, хүнс, эм, бэлдмэл, бусад/	
Тогтмол хэрэглэдэг эм, бэлдмэл, тэдгээрийн нэршил	
Бусад анхаарах зүйлс	
Яаралтай үед холбоо барих утасны дугаарууд	

Эцэг, эх, асран хамгаалагч /тамирчны хэн болохоо доогуур нь зурж тэмдэглэх/

Гарын үсэг _____ Огноо _____

Тэмцээн, бэлтгэлд оролцох тамирчинд өгөх аюулгүй байдлын зааварчилгаа
(Тамирчин)

Хавсралт 4

ТАМИРЧНЫ ОВОГ, НЭР	
КЛУБЫН НЭР	
ОРОЛЦОХ ТЭМЦЭЭН/БЭЛТГЭЛИЙН НЭР,	
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ХАЯГ	
ХУГАЦАА	
ГАЗАР/УЛСЫН НЭР	☐ улс ☐ олон улс

ОРОЛЦОГЧ ТАМИРЧИН:

- Орон нутаг, олон улсын хэмжээний тэмцээн, бэлтгэлд оролцогч тамирчин өөрийн болоод бусдын аюулгүй байдлыг хангаж дасгалжуулагч, эцэг эх, асран хамгаалагчийн чиглүүлэг, заавар зөвлөмжийг сайтар дагах
- Зарласан, товлосон цагуудыг баримтлах
- Дүр мэдэн зөвшөөрөгдсөн бүс, талбай, орон байраас гарахгүй, явахгүй байх, нэн шаардлагатай тохиолдолд багшид заавал мэдэгдэх
- Тэмцээн, бэлтгэлд оролцох оролцоо, амжилтандаа төвлөрөх
- Хаана ч явсан өөрийн зан байдал, үйлдэлдээ хянамгай байж бусдыг хүндэтгэн харилцах, ялах, ялагдах чанарыг баримтлах
- Аливаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн бүрэн зогссон үед бууж суух
- Өөрийн усны савтай явж шингэн зүйлээ тохируулан хэрэглэх
- Түргэн муудах хоол хүнс замд авч явахгүй байх
- Өөрийн эд зүйлд эзэн болох, аливаа эд зүйлсээ тухай бүрд шалгаж хяналттай явах
- Дараах мэдээллийг дасгалжуулагч болон гэр бүлийн зүгээс авсан эсэхээ шалгаарай:

Тухайн газар орны байршил, онцлог	☐
Аяллын тээврийн хэрэгсэл, цагийн хуваарь, нийт хугацаа, цуглах тарах цаг, газар	☐
Оролцох үйл ажиллагааны зохион байгуулалт, хуваарь	☐
Байрлах байр, өглөө, өдөр, оройн хоолны хуваарь мэдээлэл	☐
Хувийн зүгээс бэлтгэн явах зүйлсийн жагсаалт	☐
Багийн бүрэлдэхүүний мэдээлэл, дасгалжуулагчтай холбоо барих дугаар	☐

Танилцсан:

Гарын үсэг _____ Огноо _____